



МОНГОЛ УЛС
ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2024 оны 05 сарын 16 өдөр

Дугаар А/363

Нсөнбулаг

Г Хөрөнгө гаргах тухай Г

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 66 дугаар зүйлийн 66.1 дэх заалт, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3 дахь заалт, Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.2 дахь заалт, Засгийн газрын 2024 оны 166 дугаар тогтоол, Сангийн сайдын 2021 оны 04 дүгээр сарын 20-ны өдрийн 61 дүгээр тушаалаар батлагдсан "Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам"-ын 2.1.3 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Уламжлалт мал аж ахуйд тулгамдаж байгаа уур амьсгалын өөрчлөлтөөс шалтгаалсан сөрөг нөлөөллийг бууруулах тухай хууль, "Шинэ хоршоо" хөдөлгөөнийг олон нийтэд сурталчлах, идэвхжүүлэх, мэдээлэл түгээхэд шаардагдах зардлыг баталсугай.
2. Шаардагдах 5.000.000 (таван сая) төгрөгийг аймгийн Засаг даргын нөөц хөрөнгөөс гаргахыг аймгийн Засаг даргын Тамгын газар (Ш.Эрдэнэбат)-т зөвшөөрсүгэй.
3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хяналт-шинжилгээ, үнэлгээний хэлтэс (Э.Пүрэвжав), Санхүү төрийн сангийн хэлтэс (Х.Баатарзориг)-т тус тус үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



О.АМГАЛАНБААТАР

Аймгийн Засаг даргын
20 24 оны 05 дугаар сарын 16 -ны
өдрийн 363 дугаар захирамжийн
хавсралт

**"ШИНЭ ХОРШОО" ХӨДӨЛГӨӨНИЙГ ОЛОН НИЙТЭД
СУРТАЛЧЛАХ, МЭДЭЭЛЭЛ ТҮГЭЭХ**

№	Төсөл арга хэмжээний нэр	Эхлэх	Дуусах	Мөнгөн дүн
1.	Уламжлалт мал аж ахуйд тулгамдаж буй сөрөг нөлөөллийг бууруулах тухай хууль, "Шинэ хоршоо" хөдөлгөөнийг олон нийтэд сурталчлах, мэдээлэл түгээх	2024.05	2024.06	5,000,000
Нийт дүн				5,000,000

__оОо__

